

**Аймгийн 2017 оны төсвийн орлого нэмэгдүүлэх болон
төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал**

2016.12.05

Сайншанд сум

Илтгэгч: Аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Үржинбаяр

Аймгийн ИТХ-ын 3 дугаар хуралдаанд оролцогч эрхэм төлөөлөгч та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Орон нутгийн ТЕЗ-ийн 2017 оны төсвийн төсөлд Төрийн аудитын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн дагуу дараах санал дүгнэлтийг боловсруулан танилцуулж байна.

Санал дүгнэлтийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын шаардлагыг хангасан эсэх, аймгийн төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал дүгнэлт өгөхийг зорилоо.

Нэг. Орон нутгийн төсвийн төслийн талаар

Төсвийн төсөл боловсруулахдаа “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7.1-д заасны дагуу үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх, төсвийн тэнцэл алдагдалгүй байх, хөтөлбөрийн зорилго зорилт, хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг тодорхойлсон байх, хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх, худалдан авах бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх гэсэн шаардлагуудыг хангасан боловч дараах асуудлыг анхаарч үзэх шаардлагатай байна.

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар аймгийн ОНХС-д 4.9 тэрбум төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар батлагдаж үүнээс 341.9 сая төгрөгийг урсгал зардлыг санхүүжүүлэхээр тогтоож өгсөн байна. Гэтэл аймгийн 2017 оны төсвийн төсөлд ОНХС-аас урсгал зардалд 691.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байгаа нь батлагдсан урсгал зардлыг 350.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.
2. Хөрөнгийн орлого буюу газрын дуудлага худалдаагаар 1.0 тэрбум төгрөг оруулахаар тооцсон байна. Газрын дуудлага худалдааны орлогын 2017 оны төлөвлөгөөг 2016 онтой харьцуулахад 660.8 сая төгрөгөөр бууруулж тооцсон бөгөөд уг орлого хүлээгдэж буй гүйцэтгэлээр 21.6 хувь буюу 360.0 сая төгрөгийн

гүйцэтгэлтэй байгаа зэргээс харахад 2017 оны төсөвт дээрх орлого төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.

3. Аймгийн ИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 02/05 тоот тогтоолоор Замын-Үүд, Ханги Мандал хилийн боомтоор БНХАУ-руу зорчих гадаад, дотоодын иргэдээс хураамж авахаар тогтоосон байна. Төсвийн танилцуулгад дээрх тогтоолыг үндэслэн иргэдээс авах хураамжийн орлогыг 370.0 сая төгрөгөөр, автомашинаас авах хураамжийн орлогыг 375.0 сая төгрөг байхаар тооцсон гэх боловч төсвийн төсөлд автомашинаас авах хураамжийн орлогыг тусгаагүй байна.

Хоёр. Төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар

Аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 18.4 тэрбум төгрөгөөр төлөвлөсний 86.4 хувь буюу 15.9 тэрбум төгрөгийг татварын орлогоор, 8.2 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийг татварын бус орлогоор, 5.4 хувь буюу 1.0 тэрбум төгрөгийг хөрөнгийн орлогоор бүрдүүлэхээр тус тус тооцжээ.

Орон нутгийн төсвийн 2017 оны нийт орлогыг 2016 онтой харьцуулахад 609.0 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар нэмж төлөвлөсөн байна.

Аймгийн Аудитын газраас төсвийн орлогыг нэмэгдүүлэхээр дараах саналыг хүргүүлж байна.

Санал 1: *Нэр зааж ангилагдаагүй орлого буюу Замын-Үүд, Ханги Мандал хилийн боомтоор зорчигчдоос хураан авах хураамжийн орлогыг нэмж төлөвлөх*

Үндэслэл: Аймгийн ИТХ-ын захиалгаар Аудитын газраас Замын-Үүд сангийн 2014-2016 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дээрх орлогыг 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ.

Тухайлбал: 2014-2016 онд Замын-Үүд боомтоор жилд дунджаар 809.9 мянган иргэн зорчсон байхад Замын-Үүд санд 390-470.0 сая төгрөгийн орлого төвлөрч ирсэн байна.

Сангийн сүүлийн 3 жилийн орлогыг хилээр гарсан зорчигчийн тоотой харьцуулахад нийт зорчигчдын 50-60 хувь нь хураамж төлсөн байна. Иймд тус орлогод тавих хяналтыг сайжруулж, зорчигчдоос хураамжийг бүрэн авах ажлыг зохион байгуулбал жилд дунджаар 600.0 сая төгрөг төвлөрөх боломжтой байна. Иймд төсвийн төсөлд тусгасан Замын-Үүд сумын нэр зааж ангилагдаагүй орлого буюу 350.0 сая төгрөгийг 250.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх саналтай байна.

Санал 2: *Доньшен газрын тос ХХК-иас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгох 40.0 мянган ам.долларыг аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх.*

Үндэслэл: Төсвийн тухай хуулийн 60.2.5-д тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн

эх үүсвэрт оруулж тооцохоор байхаар заасан. Газрын тосны газар, Доньшен газрын тос ХХК-ийн хооронд 2011 онд байгуулсан гэрээний нэмэлт протоколын 3 дугаар зүйлд “*орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр 40.0 мянган ам.долларыг төвлөрүүлэх*” гэж заасан байна. Гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2013-2015 онд жил бүр 30.0 сая төгрөгийг Шинэ Дорноговь хөгжлийн санд төвлөрүүлэн зарцуулж ирсэн байна. Уг орлогыг 2017 оны төсвийн төсөлд тусгаагүй байна.

Иймд Доньшен газрын тос ХХК-иас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгож буй хөрөнгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт төсөвлөж зарцуулах шаардлагатай байна.

Гурав. Төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар

Орон нутгийн 2017 оны төсвийн суурь зарлагыг 17.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн бөгөөд үүний 79.5 хувийг урсгал зардалд, 20.5 хувийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Засгийн газраас ирэх оны төсөвт баримталсан бодлого чиглэлийн дагуу орон нутгийн төсвийн урсгал зардал болох тавилга эд хогшил худалдан авах, гадаад албан томилолт, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардал, ном хэвлэл авах зардлыг 100 хувь, бусад урсгал зардлыг өмнөх оны түвшингээс бууруулж төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийн 50.6 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг аймгийн ОНХС-д, 49.4 хувь буюу 2.4 тэрбум төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөсөн байна. Мөн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.0 тэрбум, замын сангийн хөрөнгөөр 0.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөжээ.

Аймгийн Аудитын газар нь өөрийн гүйцэтгэсэн аудит болон бусад холбогдох судалгаа, хууль тогтоомжийг үндэслэн төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулахад дараах зүйлийг анхаарах шаардлагатай гэж үзлээ.

1. Замын-Үүд сумын төсвөөс аймгийн төсөвт татан төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах

Үндэслэл: Төсвийн тухай хуулийн 58.4-т сум өөрийн төсвөөр сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх чиг үүргийг заасан байдаг. Гэтэл 2014-2016 онуудад хөрөнгө оруулалтын зардалд 870.7 сая төгрөг батлуулж, 708.0 сая төгрөгийг сум орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт заагдаагүй ажлыг санхүүжүүлсэн байна.

Сум орон нутгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт тусгагдаагүй ажлыг хөрөнгө оруулалтын зардалд тусган санхүүжилт олгосноос сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2015 онд 59.7 хувиар, 2016 оны эхний хагас жилийн байдлаар 51.5 хувиар тасрахад нөлөөлсөн байна.

Төсвийн төслийг аймгийн Аудитын газарт хугацаа хожимдуулан ирүүлж байгаагаас санал дүгнэлт өгөхөд хугацааны хувьд хэт богино байна. Тухайлбал аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2017 оны төсвийн төслийг 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан журамд¹ заасан хугацаанаас даруй 20 хоногоор хоцорч ирсэн байна.

Төсвийн төслийг хугацаа хожимдуулан ирүүлж байгаа нь төсвийн орлого, зарлагад дүн шинжилгээ хийх, санал дүгнэлт боловсруулах зэрэгт хүндрэл учруулж байна.

Аймгийн ИТХ-ын эрхэм төлөөлөгч та бүхнийг бидний хийсэн тооцоо судалгаа, нөөц боломжид тулгуурлан орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх талаар оруулж буй саналыг төсвийн төлөвлөгөөнд тусган баталж, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх саналыг хэрэгжүүлж ажиллана гэдэгт итгэлтэй байна.

¹Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 7.3 “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг аймаг, нийслэлийн Ерөнхий аудиторт жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ” гэж заасан

Анхаарал тавьсанд баярлалаа